

ОРХОН АЙМГИЙН НОГООН, ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХЭТИЙН ЗОРИЛТ (2026)-ЫГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ -2022 ОН

Орхон аймгийн Эрүүл мэндийн газар

2022.10.25

№	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт	Үнэлгээ
1	Зорилт 2.1. Хүн ам, ялангуяа ядуу болон бага насны хүүхэд, өсвөр насны охид, жирэмсэн болон хөхүүл эхчүүд, өндөр настныг тэжээллэг эрүүл ахуйн баталгаатай хүнсээр хүртээмжтэй, тогтвортой хангах.	Нийгмийн халамж нэн шаардлагатай бүлгийн жирэмсэн болон хөхүүл эхчүүдийг нэмэлт аминдэмд хамруулах ажлыг зохион байгуулах	Нийгмийн халамж нэн шаардлагатай бүлгийн жирэмсэн болон хөхүүл эхийг аминдэмжүүлэхэд зориулж аймгийн Засаг даргын 2022 оны А/171 дугаар захирамжаар батлагдсан төсвийн хүрээнд 502 эхийг хамруулахаас эхний 10 сарын байдлаар 353 буюу 70%-ийг аминдэмжүүлээд байна. Аминдэмжүүлэлтэд хамрагдсан нийт 353 эхээс цус багадалттай 201 эх байгаа нь 57 хувийг, нийгмийн халамж дэмжлэг нэн шаардлагатай бүлгийн 95 эх байгаа нь 27 хувийг, биологийн эрсдэлтэй 11 эх байгаа нь 3 хувийг, эх барихын ужиг дутагдалтай 46 эх байгаа нь 13 хувийг тус тус эзэлж байна. Аминдэмжүүлэлтийн үр дүнг тандахад цус багадалттай эхийн 80% нь бүрэн эдгэрч 30%-ийн биеийн байдал сайжирсан байна. Тайлант хугацаанд: - Эхийн аминдэмийн төсөв өмнөх онтой харьцуулахад хоёр сая төгрөг буюу 40%-аар нэмэгдэж хамрагдах эхийн тоо өмнөх онтой харьцуулахад 1,74 дахин өссөн. - Зорилтот бүлгийн жирэмсэн болон хөхүүл эхчүүдийн 27,4-ийг аминдэмжүүлэлтэд хамруулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.5%-аар нэмэгдсэн байна. - Аминдэмжүүлэлтийн үр дүн 85%-тай байна.	90
3		Баяжуулсан болон зохицуулах үйлчилгээтэй бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх талаар иргэдэд хандсан сургалт, сурталчилгааг өргөжүүлнэ	“Хоол шим тэжээлийн боловсрол олгох танхим”-ыг түшиглэн баяжуулсан хүнсний бүтээгдэхүүн иоджуулсан давс, амин дэмийн дутлаас сэргийлэх нь сэдэвт 3 удаагийн сургалт зохион байгуулж 110 хүнийг хамруулсан. Баяжуулсан болон зохицуулах үйлчилгээтэй бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр 3 төрлийн зөвлөмж бэлтгэн цахимаар сурталчилж 9150 хүнд хүргэсэн. Баяжуулсан болон зохицуулах үйлчилгээтэй бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх хүрээнд 6 сараас дээш настай хүүхдийн нэмэгдэл хоолыг бэлтгэх аргачлал, хүнсний бүтээгдэхүүнийг баяжуулах дадлага бүхий сургалт, олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийн хэрэглээ сэдэвт сургалтуудад 1129 эцэг эх, асран хамгаалагчийг хамруулан 17 төрлийн нэмэгдэл хоол бэлтгэх аргачлалд сургасан. Нэмэгдэл хоол тэжээл бэлтгэх аргазүйн зөвлөмж, гарын авлагыг 1389 эцэг эх асран хамгаалагчид түгээсэн.	90
4		Эрүүл мэндийн газрын зохистой хооллолтын кабинетыг тогтмол ажиллуулж жирэмсэн эмэгтэйчүүд, бага насны хүүхэд, асран хамгаалагч,	Зохистой хооллолтын кабинетад үзүүлэн, самбар, хүнсний нэгжийг сурталчлах шүүгээ бүхий иж бүрдэл сургалтын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнтэй болж сургалтын дэмжлэгт орчныг бүрдүүлж, үйл ажиллагаа тогтмолжсон. Тайлант хугацаанд тус танхимаар зорилтот	90

		иргэдэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг тогтмолжуулна	бүлгийн 450 иргэн үйлчлүүлснээс 60.3% нь эрүүл бус хооллодог, биеийн жингийн индексийн дундаж эрэгтэйд 27.6 кг/м.кв, эмэгтэйд 28.9 кг/м.кв буюу хэвийн үзүүлэлтээс өндөр, 30.8% нь илүүдэл жинтэй, 44,9% нь таргалалттай байсан бөгөөд зөвлөмжөөр ханган ажилласан. Зөв хооллолтын чиглэлээр 5 төрлийн 300 ширхэг зурагт хуудас, 100 ширхэг сургалт сурталчилгааны материал түгээсэн.	
5		Нийтийн хоол үйлдвэрлэлийн хоолны шим тэжээл, чанар, түүнд тавих хяналтыг сайжруулах	Аймгийн хэмжээнд нийтийн хоолоор үйлчилж буй 280 аж ахуйн нэгжээс 110 буюу 30% нь хоолны шим тэжээл, илчлэгээ тооцож ажилладаг бөгөөд нийтийн хоол үйлдвэрлэлийн шим тэжээл, чанарыг сайжруулах зорилгоор хоол хүнсний илчлэг, шимт бодисын хэмжээг тооцох сургалтад 167 хүнийг хамруулсан. Хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж буй хүмүүст зориулж хоол тэжээлийн илчлэг тооцох зөвлөмжийг боловсруулж 100 ширхэгийг хэвлүүлэн түгээж, цахимд байршуулан, 384 хүнд түгээн сурталчилсан.	70
6		Хүн амын хоол, хүнсний талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, хоол, хүнсээ сонгох, хэрэглэх, хадгалах хандлагыг өөрчлөх, хяналт тавих дадал төлөвшүүлэх, өрхийн хүнсний хэрэгцээгээ хангах, сайжруулах оролцоог нэмэгдүүлэх	Хүн амд болон хоол, хүнс үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд хоол шим тэжээлийн боловсрол олгох чиглэлээр 6 удаагийн сургалт зохион байгуулж 627 хүн хамруулсан байна. Эрүүл мэндийн газраас зохион байгуулсан нээлттэй хаалганы өдөр, өдөрлөг, аяны хүрээнд 450 хүнийг биеийн жингийн индекс, өөхлөг эдийн хэмжээг танита аппаратаар тодорхойлж, 4 төрлийн зөвлөмжийг цахимд байршуулж, 5 төрлийн 300 ширхэг зурагт хуудас, 100 ширхэг сургалт сурталчилгааны материал түгээсэн. Дэлхийн хүнсний аюулгүй байдлын өдрийг тохиолдуулан НҮБ-ын Хүнсний хангамж, аюулгүй байдлаас зохион байгуулсан 3 удаагийн цуврал цахим сургалтад 52 эмч, тогоочийг хамруулсан. А аминдэмийн ач холбогдлын талаар Номин, ETV, Тусгал телевизүүдэд мэдээлэл хийгдсэн. Сум, өрхийн эрүүл мэндийн дэргэдэх “Ээжүүдийн клуб”-ын хүнсний хангамжийг нэмэгдүүлж, өрхийн эрүүл мэндийн төвүүд өөрийн санхүүжилтээр олон найрлагат бичил тэжээлийг хэрэглэх, нэмэгдэл хоол бэлтгэх дадлага бүхий сургалтад 1129 эцэг эх асран хамгаалагчийг хамруулж, 1389 гарын авлага, зөвлөмж түгээгдсэн байна.	90
7	Зорилт 3.1. Нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэдэд зөв амьдралын дадлыг хэвшүүлж, урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлж, хүн амын дундаж наслалтыг уртасгах.	Иргэдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулж бүх шатны төрийн болон аж ахуй нэгж байгууллагын оролцоог сайжруулан, үүрэг хариуцлага, үр дүнг тооцон ажиллах	Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд нийт 552542 үзлэг хийгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэгт 187604 буюу 33,9 хувь хамрагдаж өмнөх оны мөн үеэс 5,5%-аар буурсан байна Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийн хамралт 34,2% байна. 2022 оны 05 дугаар сарын 01-нээс хүүхдийн болон насанд хүрэгсдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээ, оношилгоо зохион байгуулагдаж, тайлант хугацаанд нийт 14,943 иргэн үзлэгт хамрагдсанаас 7,258 иргэнд зөвлөгөө өгч, 672 иргэнийг анхан шатны эрүүл мэндийн байгууллагын хяналтад авч, 1,554 иргэнийг лавлагаа шатлалын эмнэлэгт шилжүүлсэн байна.	70
8		"Ажлын байранд эрүүл мэндийг	Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, эрүүл ажлын байр шалгаруулах	90

		дэмжих” бүх нийтийн аян өрнүүлэн, “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага”-ыг нэмэгдүүлэх	болзолт шалгуур болон эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг сурталчлан ажилласны үр дүнд 2022 онд 1 байгууллага шинээр, 2 байгууллага зэрэглэл ахиулахаар хүсэлт ирүүлж хамтран ажиллаж байна. Аймгийн хэмжээнд Эрүүл мэндийг дэмжигч байгууллага 71 байгаагаас боловсролын байгууллага 42, үйлдвэр аж ахуйн нэгж 11, эрүүл мэндийн байгууллага 10, бусад 8 байна. Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих аян өрнүүлэх, эрүүл мэндийг дэмжигч байгууллагыг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн төсвөөс 6,0 сая төгрөгийг шийдүүлсэн. “Өдөр бүр 30 минутыг өөртөө” аяныг эрүүл мэндийн салбарын хэмжээнд өрнүүлж, эрүүл мэндээ дээдлэгч 14 ажилтныг олон нийтэд цахимаар сурталчлан 38904 иргэнд хүргэсэн байна.	
9	Зорилт 3.2. Халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэлт, дэвшилтэт ээлтэй шинэ технологи бүхий эрүүл мэндийн оношлогоо, эмчилгээ үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах замаар нас баралтыг бууруулах	Зонхилон тохиолдох халдварт бус өвчин болон орон нутгийн тэргүүлэх өвчлөлд жил бүр судалгаа хийх	<p>“Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдалд” бидний хувь нэмэр, судлаач-2022” уриан дор эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулж 36 илтгэл хэлэлцүүлснээс улсын хэмжээнд 2 илтгэл хэлэлцүүлэгдсэн байна. Тайлант хугацаанд:</p> <ul style="list-style-type: none"> - Ундны уснаас шалтгаалсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний сүүлийн 5 жилийн байдалд судалгаа хийж, нөлөөлж буй хүчин зүйл, цаашид авах арга хэмжээний саналыг “Усны үнэ цэнэ” аймгийн хэмжээний зөвлөгөөнд танилцуулсан. - Үйлдвэрийн нөлөөллийн бүсэд амьдарч буй иргэдийн эрүүл мэндэд учруулж буй сөрөг үр дагаварт эрсдэлийн үнэлгээ хийж, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, тулгамдсан асуудлыг цагаан тоосны эрсдэлийг үнэлэх, бууруулах салбар зөвлөлийн уулзалтад танилцуулсан. - Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ийн 20-59 насны 250 албан хаагчийг архины хэрэглээний түвшинг тогтоох сорилд хамруулсан ба судалгааны үр дүнд 40% нь I-р түвшин, 30% нь II-р түвшин, 20% нь III-р түвшин, 10% нь IV-р түвшний зэрэглэлд хамаарч байгаа тул III, IV-р түвшний хэрэглэгчдийг сэтгэл зүйн сургалт, эмчилгээнд хамруулсан. - 5 сургуулийн ахлах ангийн 885 сурагчаас “Өсвөр насны хүүхдийн сэтгэл гутрал, стресс, өөрийн үнэлгээ, цахим хамаарлын түвшин болон түүний гэр бүлийн байдал, оршин суугаа харьяалал хоорондын хамаарлын байдлыг судлахад 55.4% өөртөө итгэх итгэлтэй, 1.8% өөрийн үнэлгээ багатай, 14.4% сэтгэл гутралын хүндэвтэр түвшин, 7.9% сэтгэл гутралын хүнд түвшинд, 33.2% стрессийн түвшин өндөр, 70,9% интернэтийг эрсдэлтэй нөхцөлд ашигладаг гэсэн үр дүн гарсан байна. Иймд мэргэжлийн 11 сэтгэл зүйч 91 хүнд сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөө, 24 төрлийн сэтгэц оношилгоонд 255 иргэн, бүлгийн сэтгэл засалд 240 иргэнийг хамруулсан байна. 	90
10		Засгийн газрын “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн хүрээнд зорилтот бүлгүүдэд элэгний хорт хавдар, В,С	“Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөр 2020 онд 84,1%-тай хэрэгжиж дууссан. “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөр, “Элэгний вирусгүй Эрдэнэт хот” аяны үйл ажиллагааг эрчимжүүлэх хүрээнд нийт 121 сая	90

		<p>вирусийн халдварыг эрт илрүүлж, өвчлөлийг бууруулах, эмчлэх ажлыг зохион байгуулах</p>	<p>төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэн үйл ажиллагааг зохион байгуулсны дүнд шинжилгээнд хамрагдах зорилтот бүлгийн 73.3%-ыг хамруулж улсад тэргүүлсэн.</p> <p>2022 оны байдлаар элэгний В, С, Д вирусийн илрүүлэг шинжилгээнд 8658 иргэн хамрагдсанаас 555 хүн буюу 6.4 хувьд нь С вирус, 551 хүн буюу 6.3 хувьд нь В вирус илэрсэн. Вирусийн эмчилгээ хийх эрх бүхий 6 эмчийн хяналтад 258 иргэн эмчилгээ хийлгэж байна. Нярайн төрсний дараах 24 цагийн дотор гепатитын В вирусийн эсрэг дархлаажуулалтын хамралт 99.8%, 2 настай хүүхдийн А вирусийн эсрэг дархлаажуулалтын хамралт 98.2%-тай байна. Эрүүл мэндийн байгууллагын 176 ажилтан, эрсдэлт бүлгийн 559 хүн ам В вируст гепатитын эсрэг вакцинд сайн дураар хамрагдсан. Элэгний хорт хавдрын нас баралт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 0.7 промиллоор өссөн бол элэгний хатуурлын нас баралт 10000 хүн амд 0.8 промилл буюу өнгөрсөн оны мөн үеийн түвшинд байна.</p>	
11		<p>“Элэгний вирусгүй Эрдэнэт хот” аяныг зохион байгуулах, үйл ажиллагааг нь дэмжиж ажиллах</p>	<p>“Элэгний вирусгүй Эрдэнэт хот” аян 2016-2020 онд хэрэгжиж дууссан. Тус аяныг хэрэгжих хугацаанд орон нутгаас 178,8 сая, ДЗОУБ-ЭНХХ-өөс 10 сая төгрөгийг шийдвэрлэж доорх үйл ажиллагааг зохион байгуулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Тус аяны хүрээнд сургалтад 3235 хүн, В, С вирусийн шинжилгээнд 1995 хүн, В вирусийн сайн дурын вакцинд 474 хүн, зорилтот бүлгийн 1000 иргэнийг В гепатитын эсрэг дархлаажуулалтын I, II тунд хамруулсан. - Элэгний хатууралтай 1064 иргэнийг ЭХО шинжилгээ болон, нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулснаас элэгний хорт хавдар шинээр 12 оношлогдож, элэгний үүсгэвэр, элэгний хорт хавдар эмчлүүлээгүй болон урьд нь эмчлэгдсэн нийт 226 хүнийг бүртгэн, хяналтад оруулсан. - ДЗОУБ-д бүртгэлтэй хүүхдүүдийн эцэг эх болох 802 хүнийг илрүүлэгт хамруулж, 11.2% /В вирус 68, С вирус 22/ нь элэгний вирустэй илэрч, вакцинд 698 хүн, сургалт, сурталчилгаанд 800 хүнийг хамруулсан - Элэгний В вирусийн халдвартай эхээс төрж буй нярайг халдвар авахаас сэргийлсэн “В вирусийн халдваргүй нярай” төсөлд 30,0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэснээр В вирус тээгч эхээс төрсөн нярайг В вирусийн халдвараас сэргийлэх зорилгоор “Нераbig” иммуноглобулиныг 226 нярайд хийж халдвараас сэргийлсэн байна. - Эмч дэд хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн 9,0 сая төгрөгийн санхүүжилтээр элэгний В вирусийн эсрэг вакцины дархлал тогтцын шинжилгээг Онош лабораторитой хамтран 510 эмч, 	-

			<p>эмнэлгийн ажилтныг хамруулан хийж дүгнэхэд 9,3%-д дархлал тогтоогүй, 16%-д сул дархлал тогтож, 74,7% дархлал бүрэн тогтсон байна.</p> <ul style="list-style-type: none"> - 10068 эрүүл мэндийн даатгалгүй иргэнийг элэгний В, С вирусийн эрт илрүүлэгт хамруулсан. Эрүүл мэндийн даатгал төлөгдөөгүй үзлэгт хамрагдсан 284 хүний эрүүл мэндийн даатгалын төлбөрт 7.5 сая төгрөгийг орон нутгаас 100% шийдвэрлэсэн - Аймгийн хэмжээнд 4500 иргэнд үзлэг хийгдсэнээс хорт хавдрын 23 шинэ тохиолдлыг илрүүлж, 14 хүнд мэс заслын эмчилгээ хийж, 9 хүнийг ХСҮТөвд эмчилгээнд илгээж, 257 иргэнийг хяналтад авлаа. 187 иргэн орон нутагтаа тусламж үйлчилгээг авсан байна. 	
12		Халдварт бус өвчний эрт илрүүлгийг үе шаттайгаар зохион байгуулах	<p>Тайлант хугацаанд хөх, умайн хүзүү, элэгний хатуурал, хорт хавдар, чихрийн шижин, цусны даралт ихсэх зэрэг өвчнийг эрт илрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж үр дүнг тооцон ажилласан. Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийг эрчимжүүлэхээр орон нутгаас 12,0 сая төгрөгийг шийдвэрлэсэн. Эрт илрүүлэг үзлэгийн дундаж хувь тайлант хугацаанд 32%-д хүргэхээр төлөвлөснөөс 34,2% байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Артерийн гипертензи эрт илрүүлгийн үзлэгт нийт 25909 буюу хамрагдвал зохих хүн амын 37,7 хувийг эзэлж, өмнөх оноос 3,3 хувиар буурч үр дүнгийн үзүүлэлтээр 0.7 хувь нь онош батлагдсан. - Чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн үзлэгт нийт 16246 хамрагдвал зохих хүн амын 47,9 хувийг эзэлж, өмнөх оноос 8,6 хувиар буурч, үр дүнгийн үзүүлэлтээр 0.2 хувь онош батлагдсан байна. - Умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгт зорилтот насны нийт 1675 эмэгтэй хамрагдаж, хамрагдвал зохих насны эмэгтэйчүүдийн 30,1 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 9,4 хувиар буурсан ба 1390 буюу 85.1 хувь нь пап шинжилгээнд хамрагдсан байна. - Хөхний эрт илрүүлэг үзлэгт 10357 эмэгтэй хамрагдаж, хамрагдвал зохих насны эмэгтэйчүүдийн 30,1 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 29,4 хувиар буурсан байна. <p>Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах, сэргийлэх чиглэлээр 35 төрлийн постер зөвлөмжийг 18569 иргэнд хүргэж, 3 өдөрлөгт давхардсан тоогоор 4786 иргэнийг хамруулан 6 эх бэлтгэл, 3 шторка бэлтгэн цахим хуудсаар иргэдэд хүргэсэн.</p>	90
13		Хүн амын дундах ДОХ/ХДХВ/БЗДХ-ыг эрт илрүүлэх, оношлох, эмчлэх ажлыг эрчимжүүлэх	<p>Тайлант хугацаанд 3850 иргэн бэлгийн замаар дамжих халдварын эрт илрүүлэг, оношилгоонд хамрагдсанаас 70,9% нь урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байна. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд ХДХВ-ийн шинжилгээнд 1939, тэмбүүгийн шинжилгээнд 1961 иргэнийг хамруулсан. Хүн амын нас , хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, үзлэг, шинжилгээ, оношлогооны хүрээнд ХДХВ/Тэмбүү илрүүлэх шинжилгээнд хамрагдах 18-30, 31-45 насны 1026</p>	90

			иргэн эрт илрүүлэг, шинжилгээнд хамрагдаж 4.2%-д тэмбүү өвчин оношлогдож БОЭТ-ийн ДОХ/БЗДХ-ын кабинетэд эмчилгээнд хамруулахаар илгээсэн. Тайлант хугацаанд бэлгийн замаар дамжих халдварын 147 тохиолдол бүртгэгдсэнээс 48,9%-ийг тэмбүү, 23,1%-ийг заг хүйтэн, 2,79%-ийг трихомониаз тус тус эзэлж, нийт халдварт өвчний 3,1%-ийг эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 0,8%-аар өсч, 10 000 хүн амд 13,9 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 1,8 промиллоор тус тус буурсан байна. ДОХ/ХДХВ/БЗДХ-ыг эрт илрүүлэг, оношилгооны хамрагдалтыг эрчимжүүлэхээр 7 төрлийн зурагт хуудсыг цахим орчинд байршуулан 13240 хүнд хүргэсэн байна.	
14		Хорт хавдартай иргэдийн эмийн зардалд дэмжлэг үзүүлэх	Хорт хавдартай иргэдийн эмийн зардалд дэмжлэг үзүүлэхээр аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд 70.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэснээс аймгийн Засаг даргын 2022 оны А/214, А/432, А/610 дугаар захирамжаар 2022 оны эхний 10 сарын байдлаар 130 иргэнд 47,5 сая төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлээд байна.	90
15		Нөхөн үржихүйн насны өртөмтгий бүлгийн эмэгтэйчүүдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан эмчлэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулах	Тайлант хугацаанд өсвөр үе, зорилтот бүлгийн 546 эмэгтэйг нөхөн үржихүйн насны 4640 эмэгтэйг урьдчилан сэргийлэх үзлэг, сургалтад хамруулсан нь нийт нөхөн үржихүйн насны эмэгтэйн 18,5 %-ийг эзэлж зорилтот түвшинд хүрсэн. 16-49 насны эмэгтэйчүүдийн 62,1 хувь гэр бүл төлөвлөлтийн 5 төрлийн арга хэрэгсэлд хамрагдаж байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 4,5 хувиар нэмэгдсэн.	90
16		Ерөнхий боловсролын сургууль, МСҮТ болон их, дээд сургуулиудыг их эмчтэй болгох асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх	2018 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн Эрүүл мэндийн сайд, Боловсрол соёл шинжлэх ухаан, спортын сайдын хамтарсан “Үлгэрчилсэн загвар, жагсаалт батлах тухай” А/494, А/761 дүгээр тушаалаар ерөнхий боловсролын сургууль болон хүүхдийн цэцэрлэгийн эмчийн ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загвар батлагдаж, хүний их эмч, сувилагч, бага эмчийн мэргэжлийн дипломтой хүн сургууль, цэцэрлэгийн эмчийг хийхээр тусгагдсан. Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын 26 сургуульд 22 эмч ажиллаж байгаагаас 2 их эмч ажиллаж байна. Эрдэнэт их сургуульд гэрээгээр их эмч, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд бага эмч ажиллаж байна. Эрүүл мэндийн газраас дээрх сургуулиудын эмч нарыг сар тутам 2 удаа шинэ мэдээллээр ханган, чадавхжуулах сургалтад хамруулан, мэргэжил арга зүйгээр ханган, үйл ажиллагаанд нь хяналт тавин ажилласан.	90
17		Хүүхдийн амны хөндийн өвчнийг оношлох, эмчлэх ажлын хүрээнд Ерөнхий боловсролын сургуулиудад шүдний кабинет, лабораториудыг байгуулах ажлыг судлах	2017-2019 онд ерөнхий боловсролын сургуулийн дэргэдэх 3, 4, 5 дугаар сургуулийн дэргэд орон нутгийн санхүүжилтээр шүдний кабинет ажиллуулсан. Шүдний эмчийн цалин, шүдний эмчилгээний эм, материалыг худалдан авах зардал төсөвт суугдаагүй, хүний нөөцийн дутагдалтайгаас тайлант хугацаанд ажиллаагүй байна.	70
18		Сүрьеэгийн эрт илрүүлэлт,	Тайлант хугацаанд сүрьеэгийн үзлэгт нийт 8859 хүн хамруулснаас 87,5%	90

		<p>оношилгоо эмчилгээг сайжруулан, тандалт судалгааг зохион байгуулах, сүрьеэгийн халдварыг түргэн хугацаанд оношлох шинэ технологийг нэвтрүүлж, дижитал рентген аппаратаар хангах</p>	<p>нь урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт хамрагдсан байна. Сүрьеэгийн эрт илрүүлгийн үзлэг шинжилгээг эрчимжүүлэхээр Бүсийн оношилгоо эмчилгээний төвтэй хамтран 186-р цэргийн ангийн 168 хугацаат цэрэг, алба хаагч, Эрдэнэт үйлдвэрийн 26 ажилтан, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газрын нээлттэй 427-р хорих ангийн албан хаагч болон хүмүүжигч 198 хүнийг хамруулснаас идэвхтэй сүрьеэ 14 тохиолдол илэрч эмчилгээнд хамрууллаа. Сүрьеэгийн диспансерын хяналтад 55 өвчтөн эмчлэгдэж байна. Эмчилгээний амжилт 79%-тай байна. Тайлант хугацаанд сүрьеэгийн өвчлөл 48 бүртгэгдэж, 10000 хүн амд 4,5 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 0,9 промиллоор нэмэгдсэн байна. Тус хугацаанд тандалт судалгаа 2 хийгдсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Сүүлийн 4 жилд бүртгэгдсэн сүрьеэгийн шинэ тохиолдлуудын дунд тандалт, судалгаа хийхэд тохиолдлын тоо 5 болон 10 саруудад босго үзүүлэлтээс дээгүүр, эрэгтэйчүүдийн сүрьеэгийн тохиолдол эмэгтэйчүүдтэй харьцуулахад 40%-аар илүү бүртгэгдсэн бөгөөд өвчлөл 15-29 нас, 65-аас дээш насныхны дунд өндөр, нас баралт 60-аас дээш насныхан дунд их, нийт бүртгэгдсэн тохиолдлын 61% -д уушгины сүрьеэ илэрч байгаа нь цаашид сүрьеэгийн халдвар өсөх хандлагатай байгааг харуулж байлаа. - Сумын эмч мэргэжилтнүүдийн холбооноос хавьтлын үзлэг шинжилгээнд зарцуулагдах 1.4 сая төгрөгийг шийдвэрлэн сүүлийн 4 жилийн сүрьеэ өвчин батлагдсан 270 иргэний ойрын хавьтлын 325 иргэнийг өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран дижитал рентген болон сүрьеэ илрүүлэх асуумжид хамруулснаар сүрьеэгийн сэжигтэй 8 тохиолдлыг илрүүлж цэрний түрхцийн шинжилгээнд илгээснээс 1 эерэг, уушгины сөрөг 2, хавдар 1 тохиолдлыг илрүүлсэн. 	
19		<p>Хуулийн дагуу оношилгооны урвалж, зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэлээр хангах, гэрээгээр хангагдаж байгаа эмийн чанар хүртээмж хэрэглээнд хяналт тавих, худалдаанд байгаа эмийн үнийг иргэдэд нээлттэй болгох</p>	<p>Тайлант хугацаанд БОЭТ-д төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 45 багцад 3,0 тэрбум төгрөгийн нээлттэй тендер зохион байгуулсан. Үүний дагуу 43 компанитай гэрээ байгуулан 95,6% тендерээр авч байна. Мөн ерөнхий гэрээгээр худалдан авах 34 нэрийн эм, 5 нэрийн эмнэлгийн хэрэгслийг 12 компанитай 400 сая төгрөгийн жилийн гэрээ байгуулан ажилласан. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 70 сая.төгрөг буюу 17,5%-аар илүү худалдан авалт хийгдсэн. 49 эмийн санд “Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS5260:2015 стандарт”-ын хэрэгжилт дунджаар 90,1% үнэлгээтэй гарсан нь өмнөх онтой харьцуулахад стандартын хэрэгжилт 0,4%-аар, эм ханган нийлүүлэх байгууллагад “Эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт түгээлтэд тавих шаардлага MNS5530:2014 стандарт-ын хэрэгжилт дунджаар 93,4% байгаа нь өмнөх онтой харьцуулахад 5,3%-аар сайжирсан байна. Худалдаанд байгаа эмийн үнийг иргэдэд нээлттэй ил тод байдлыг хангахаар эмийн сангууд эмийн үнийг иргэдэд харагдахуйцаар байршуулан, Эрүүл мэндийн даатгалын үндэсний</p>	90

			шинэчлэн батлагдсан тогтоолыг хэвлэмэл нэг төрлийн самбараар иргэдэд мэдээлэл өгч ажилласан.	
20		Цахим эрүүл мэндийн төслийг хэрэгжүүлэх	Цахим эрүүл мэнд төслийн хүрээнд орон нутгийн төсвийн 200,0 сая төгрөгийн санхүүжилтээр 39 тоног төхөөрөмж нийлүүлэгдэн, хэрэгжилт 100%-тай байна. Аймгийн хэмжээнд хэрэгжиж буй “Цахим Эрдэнэт-1” төслийн хүрээнд хийгдэж буй нэгдсэн платформд “Эрүүл мэнд” аппликейшнийг хөгжүүлж байна. Мөн тус хөтөлбөрийн хүрээнд сум, өрхийн эрүүл мэндийн төвийн гэрийн дуудлага, гэрийн эргэлт болон Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн түргэн тусламжийн дуудлагын үед цахим программд үзлэгийн бүртгэл хөтлөх ажиллагааг хялбаршуулах, хөнгөлөлттэй эмийн жорыг тухайн газарт нь бичиж, коды олгох зориулалтаар ашиглах зөөврийн 20 ширхэг таблетаар хангасан.	90
21		Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн цаг товлох, хөтөч, лавлагаат үйлчилгээг өргөжүүлэх	Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 2021 оны 11 дүгээр сараас “Хан шунхлай нуруу” ХХК-ийн 6 хөтөч сувилагчийг ажиллуулснаар үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж 90% болж өмнөх оноос 15%-иар нэмэгдэж, иргэдийн тодорхойгүй, мэдээлэлгүй, ойлгомжгүй байдал 88,2 хувиар багассан. Аймгийн Засаг даргын 2022 оны А/105 дугаар захирамжаар Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн дэргэд хэрэгжүүлж байгаа “Сэтгэлд нийцсэн хөтөч” үйлчилгээ ажиллуулахад дэмжлэг үзүүлж, 6 хөтөч сувилагчийн цалин, нэг удаагийн хэрэгсэлд 35,2 сая төгрөгийг шийдвэрлэсэн. “Хан шунхлай нуруу” ХХК-ийн Хөтөч үйлчилгээнээс 14 хоног тутам “Герман Монголын хамтын ажиллагааны нийгэмлэг”-ийн Froggress төслийн болон “Илтгэх урлагийн индэр” төрийн бус байгууллагатай хамтарсан төлөвлөгөөт сургалт, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоотой хамтран дохионы хэлний анхан шатны сургалтыг зохион байгуулан ажилласан. Хөтөч үйлчилгээний ажилтнууд суурь судалгаа, явцын судалгаа, хөндлөнгийн хяналт хийж нийт 28 санал, 4 иргэний гомдлыг Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн удирдлагын багт танилцуулж шийдвэрлүүлсэн. Хөтөч сувилагч ажилласнаар амбулаторийн хэсэгт хөтөөр ажиллаж байсан 3 сувилагчийг үндсэн ажлаа хийж байна. Цаг товлолыг сараар биш долоо хоногоор бүртгэдэг болсноор иргэд үзүүлэх цагаа долоо хоног бүр хурдан шуурхай авдаг болсон. Эмч нарын цагийг иргэдэд мэдээлэл өгөх зорилгоор хөндлөнгөөс хянадаг болсноор ажлын цаг ашиглалт, үйл ажиллагаа эрс сайжирч, иргэдийн хүлээгдэл 88.2 хувиар багассан.	90
22	Зорилт 3.4. Хүн амын эрэлт хэрэгцээнд нийцсэн, чанар аюулгүй байдлыг хангасан, хариуцлагатай, үйлчлүүлэгч төвтэй эмнэлгийн тусламж үйлчилгээний тогтолцоог	Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг цогц байдлаар зохион байгуулах, шинээр байгуулагдсан хорооллын дунд эрэлт хэрэгцээ, стандартыг үндэслэн Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг шинээр ажиллуулан,	Өрхийн эрүүл мэндийн төвийн 7 нь стандартын шаардлага хангасан байртай, 1 өрх багийн байранд байрлан тусламж үйлчилгээг үзүүлж байгаа бөгөөд тоног төхөөрөмжийн хангалт 88.4%, хүний нөөцийн хангалт 90.1% байна. Аймгийн Засаг даргаар батлуулсан удирдамжаар ажлын хэсэг байгуулагдаж өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагаа, хууль	90

	хөгжүүлэх.	иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ойртуулах	тогтоомж, шийдвэр, эрүүл мэндийн статистик үзүүлэлт, гүйцэтгэлийн гэрээний хэрэгжилтэд сүүлийн 5 жилийн байдлаар үнэлгээ хийж, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн хүн амыг дахин төлөвлөх санал, анхан шатны тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх төлөвлөгөөг боловсруулан аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар оруулан хэлэлцүүлсэн.	
23		Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тоног төхөөрөмж, нөхөн сэргээх эмчилгээ, лабораторийн чадавхыг сайжруулах	Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тоног төхөөрөмжийн хангалт 88.4%, байна. Тайлант хугацаанд орон нутгийн 50,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 8 өрхийн эрүүл мэндийн төвийг билиметр болон УВЧ аппаратаар хангасан. Жаргалант суманд орон нутгийн хөгжлийн сангийн 16,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 5 нэр төрлийн эмнэлгийн хэрэгсэл, орон нутгийн 10,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар сургалтын өрөөг бүрэн тохижуулсан. Сум өрхийн эрүүл мэндийн төвүүдэд эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр сэргээн засах тусламж үйлчилгээ болон оношилгоо шинжилгээг хийж тайлант хугацаанд 1730 иргэнд сэргээн засах тусламж үйлчилгээ, 4422 иргэнд оношилгоо шинжилгээний тусламж үйлчилгээг үзүүлж 124,7 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.	90
24		Яаралтай түргэн тусламжийн төвийг байгуулж, шаардлагатай тоног төхөөрөмж, түргэн тусламжийн автомашинаар хангах.	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Яаралтай тусламжийн хүлээн авах тасагт Жайка олон улсын хамтын ажиллагааны төслөөс 120 сая төгрөгийн 4D ЭХО аппарат, амилуулах өрөөнд суурин амьсгалын аппарат шинээр суурилуулсан. Ажиглах хяналтын хэсэгт телемедицины дэлгэцийг дагалдах тоног төхөөрөмжийн хамт байрлуулан лавлагаа шатлалын эмнэлгүүдтэй шууд холбогдож 30 иргэнд зөвлөгөө авсан. Шархны анхны цэгцлэлт хийх мэс заслын өрөөнд туяагаар гар ариутгагч, оёдлын иж бүрдэл 3 ширхгээр хангаснаар эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар гарахаас сэргийлсэн. Яаралтай тусламжийн хүлээн авах тасгийн багаж тоног төхөөрөмжийн хангалт 85% болж өмнөх оны мөн үеэс 5%-аар нэмэгдэж, яаралтай тусламж үзүүлэх чадавх 90%-д хүрсэн. Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд яаралтай тусламж үзүүлэх нэгжийг шинээр байгуулж амилуулах суурь тусламжийг үзүүлэх багийг томилон гардан үйлдлийн сургалтыг Бүсийн оношилгоо эмчилгээний төвтэй хамтран 2 удаа зохион байгуулж чадавхжуулсан. Тус нэгжүүдэд хяналтын монитор 8, хүчилтөрөгч өтгөрүүлэгч 10, отсос 8, дефибрилятор 5 ширхгийг байрлуулсан ба хүчилтөрөгчийн гуурс нэг сарын нөөцтэй, амин чухал эм, тариа 1-2 сарын нөөцтэй байна. Үйлсбадрах өрхийн эрүүл мэндийн төв, Бүсийн оношилгоо эмчилгээний төвд Жаргалант сумын эрүүл мэндийн төвд төрөх болон яаралтай тусламжийн иж бүрдлийн цүнхээр хангагдсан. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн яаралтай тусламжийн тоног төхөөрөмжийн хангалт 95%, гардан үйлдлийн чадавх 89%-тай байна.	90

			Баян-Өндөр мед нэгдсэн эмнэлэгт эрчимт эмчилгээний тасгийг нээн ажиллуулж багаж тоног төхөөрөмжөөр 100% хангасан. Хувийн хэвшлийн ортой эмнэлгүүдийн яаралтай тусламжийн нэгжийн багаж тоног төхөөрөмжийн хангалт 85%, гардан үзүүлэх чадавх 82%-тай байна. Тайлант хугацаанд Эрүүл мэндийн яамнаас түргэн тусламжийн тасгийг тоноглол бүхий 1 автомашинаар хангаснаар 13 түргэн тусламжийн машин дуудлагад үйлчилж байна.	
25		Эмч нарын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, тэдний төлөвшил, ёс зүй, хандлагыг сайжруулах	Тайлант хугацаанд төрийн санхүүжилт болон хувийн зардлаар үндсэн болон төрөлжсөн мэргэжлийн сургалтад 79 эмч, 91 сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтэн, нийт 170 эмч, эмнэлгийн мэргэжилтэн суралцаж байна. Нэн шаардлагатай хүүхдийн мэс засал, компьютер томограф соронзон давтамжит дүрс оношилгоо судлалаар улсын төсвийн санхүүжилтээр Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2 эмчийг сургалтад хамруулсан. БОЭТ-ийн “Ерөнхий мэргэшил судлал”-аар тайлант хугацаанд 1 резидент эмч суралцаж байгаа ба “Эрчимт эмчилгээний сувилахуй”, Яаралтай тусламжийн сувилахуй” чиглэлээр төгсөлтийн дараах сувилахуйн сургалтыг 2022 оны 10 сарын 01-ээс эхлүүлж 16 сувилагч элсэн суралцаж байна. Нийт эмч, эмнэлгийн мэргэжилтний 74,4% ажлын байрны, алсын зайн сургалтад хамрагдаж, 71 эмч, эмнэлгийн мэргэжилтэн лавлагаа шатлалд болон анхан шатлалд сэлгэн ажилласан байна. Төвийн болон орон нутагт зохион байгуулсан ажлын байран дээр дадлагажуулах 4 удаагийн сургалтад 100 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна. Докторын зэрэгтэй эмч 0,2%, магистрын зэрэгтэй эмч, эмнэлгийн мэргэжилтэн 12%-тай байна. Төгсөлтийн дараах сургалтад эмч мэргэжилтнүүдийн 12.9% нь, нийгмийн дэмжлэгт нийт эрүүл мэндийн ажилтны 17% нь хамрагдсан байна. Эрүүл мэндийн газрын дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооноос тайлант хугацаанд 39 удаагийн сургалтад давхардсан тоогоор 1024, багц цагийн сургалтад 285 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамрууллаа. Тайлант хугацаанд Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороонд гомдол ирээгүй.	90
26		Эмнэлгийн байгууллагад ажиллагчдын цалин урамшууллыг нэмэгдүүлэх, орон сууц болон бусад нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлж, хүний нөөцийн тогтвортой ажиллах боломжийг бүрдүүлэх, ажиллах орчин нөхцөлийг хангахад дэмжлэг туслалцаа үзүүлэх	Монгол улсын Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолын дагуу эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний ажилчдын цалин 13% нэмэгдсэнээр олгож байна. Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын дагуу төрийн захиргааны ажилчдын цалинг олгож байгаа бөгөөд Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны 01 сарын 31-ны Б/11 дугаар тушаалын дагуу Эрүүл мэндийн газрын 4 мэргэжилтэнд төрийн захиргааны албан хаагчийн зэрэг дэвийг журмын дагуу нэмэгдүүлсэн. Мөн 2022 оны 06 сарын 01-ний өдрөөс эхлэн ЭМГ-ын төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг 10-30% нэмэгдүүлсэн. Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь 2022 оны 08 сарын 01-ний өдрөөс төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг дахин 10% нэмсэн байна.	90

			Төрийн албан хаагчдад зориулсан орон сууцнаас БОЭТ-ийн 40 ажилтантай зах зээлийн ханшнаас хөнгөлөлттэй үнээр буюу м/кв нь 1,350.000 төгрөг байхаар гэрээ байгуулсан бөгөөд одоогоор барилгын гүйцэтгэл 20%-тай явагдаж байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь 30 ажилтанд орон сууц худалдан авахад зориулан урьдчилгаа төлбөр тус бүр 20,0 сая төгрөгийг олгосон. Эрдэнэт сувиллын цогцолбор нь мөн эрүүл мэндийн ажилтнуудынхаа нийгмийн баталгааг дэмжин орон сууц худалдан авсан нийт 6 ажилтанд тус бүр 13.0 сая төгрөгийн дэмжлэг олгосон байна. Эрдэнэт медиал эмнэлэг нь “Эрүүл мэндийн ажилтны өдөр”-ийг тохиолдуулан 3 албан хаагчид гадаад оронд аялах эрхийн бичиг, 3 албан хаагчид орон сууцны урьдчилгааг олгох эрхийн бичгийг тус тус олгосон.	
27	Зорилт 4.2. Төр болон хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд түшиглэн хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадвартай, мэргэжилтэй ажилтан бэлтгэх	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийг түшиглэн “Бүсийн анагаах ухааны мэргэжил дээшлүүлэх төв” байгуулна.	“Монгол улсын анхан ба хоёр дахь шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах нь” төсөл Орхон аймагт 5 дахь жилдээ амжилттай хэрэгжиж байна. ЭМЯ-ны дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн 2018 оны 10 дугаар тогтоолоор “ЕРӨНХИЙ МЭРГЭШИЛ СУДАЛ”-ын үндсэн мэргэшлийн сургалтыг Монгол улсад анх удаа орон нутагт Орхон аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвд явуулж, 2018-2022 оны хичээлийн жилд 12 суралцагч эмчийг сургаж төгсгөсөн. Тайлант хугацаанд 1 резидент эмч суралцаж байна. “Эрчимт эмчилгээний сувилахуй”, Яаралтай тусламжийн сувилахуй” чиглэлээр төгсөлтийн дараах сувилахуйн сургалтыг 2022 оны 10 сарын 01-ээс эхлүүлж 16 сувилагч элсэн суралцаж байна.	90
Хэрэгжилтийн дундаж хувь-87,7%				

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:ХШУДАХМ

ТАНИЛЦСАН: ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА

Г.ЭНХЖАРГАЛ

Д.СҮХЭЭ